



Улс, аймгийн нэгдсэн төсөв боловсруулах

MERIT төслийн зөвлөх, Мишэл Филион

Агуулга

- Улс, аймгийн нэгдсэн төсөв боловсруулах
- Төсвийн үе шатууд
- Гүйцэтгэлд суурилсан төсөвлөлт
- Хариуцлага

Улс, аймгийн нэгдсэн төсөв боловсруулах

- Төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагын эрхлэх асуудлуудын нэг юм.
- Томоохон байгууллагууд (ОУВС, ЭЗХАХБ гм)-ын норм, стандартыг баримталдаг.
- Өнгөрсөн хэдэн арван жилд ихээхэн өөрчлөгдсөн.
- Олон улсын норм, практикт тулгуурласан хэдий ч тухайн улсын онцлогийг тусгадаг.

Төсөв

Төсөв нь төрийн чиг үүргийн хүрээнд тодорхой хугацаанд зорилго, зорилт бүхий цогц арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө юм. Төлөвлөгөө нь шаардлагатай нөөцийн тооцооллыг өмнөх нэг буюу түүнээс дээш тайлант хугацааны гүйцэтгэлтэй харьцуулсан боломжит нөөцийн тооцоолол, ирээдүйд шаардагдах хөрөнгийн хамтаар харуулдаг.

Төсвийн үе шатууд

- Бэлтгэх, төлөвлөх
- Батлах
- Хэрэгжүүлэх
- Үнэлэх

Төрөөс баримтлах бодлого

Төр төсвийн орлого болон зарлагыг тэнцвэржүүлэхийг илэрхий чармайдаг. Улсын төсөвт санхүү, нийгэм, эдийн засгийн бодлогыг тоймлон тусгахын зэрэгцээ энд хийгддэг гол тооцоолол нь ирэх жилийн санхүүгийн зарлагыг дэлгэрэнгүй төлөвлөж оруулдаг.

Зарчим

- Нэгдмэл байх – нэгдсэн төсөвт орлого орж, түүнээс зарлага гардаг байх
- Тэнцвэржүүлэх – төсвийн нийт орлого нийт зарлагаа нөхөж байх
- Жилдээ багтах

Онцгой тохиолдол

Уругвай улс Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд батлагдсан төсөвтэй байдаг. Засгийн газар бүрэн эрхийнхээ хугацааны эхэнд парламентын танхимд төсвөө өргөн барьж, батлуулдаг бөгөөд дараагийн сонгууль хүртэл тухайн төсвийг баримталдаг.

АНУ-ын Төсвийн зарлага, санхүүгийн хариуцлагын хөтөлбөр, төсвийн мөчлөг



Гүйцэтгэлд суурилсан төсөвлөлт

Гүйцэтгэлд суурилсан төсөвлөлт аливаа байгууллагын бүтцийн нэгж бүрийн хувьд зарцуулах нөөц болон үзүүлэх үйлчилгээг хооронд нь уялдуулан тусгадаг. Дэлхийн улс орнууд татвар төлөгчдөөс цуглуулсан мөнгө болон холбооны ЗГ, төрийн төв болон орон нутгийн захиргааны байгууллагуудын үзүүлж буй үйлчилгээний үр дүнгийн хоорондох уялдаа холбоог харуулахын тулд төрийн байгууллагууд энэ төрлийн төсвийг түгээмэл ашигладаг.

Хариуцлага

- Хариуцлага нь төсвийг төлөвлөж эхлэхээс эхлээд хэрэгжилтийн төгсгөлд төрийн хяналт шалгалт буюу гүйцэтгэлийн аудит хийж, үр дүнг тайлагнах хүртэл бүх үйл явцыг бүрэн хамарна.
- Босоо тогтолцоонд тухайн байгууллага чиг үүргээ гүйцэтгэж байгаа эсэхэд дээд шатны парламентын гишүүд, төрийн хяналтын байгууллага хяналт тавьдаг.
- Хэвтээ тогтолцоонд олон нийт, иргэний нийгмийн байгууллагууд, бусад талууд хяналт, үнэлгээнд оролцож, хяналт тавьдаг байна.

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт гэдэг нь жендэрийн тэгш байдлыг хангах, охид эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсвийн бодлого, удирдамжтай байхыг хэлнэ. Аль ч шатны төрийн байгууллага, түүний төсвийн ерөнхийлөн захирагч нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээг үнэлж, гол үр дүн, зорилгыг тодорхойлж, төрийн сангийн хөрөнгийг төлөвлөх, хуваарилах, тараах, үр дүнг хянаж үнэлэх чадвартай байвал зохино.

Улс орнууд жендэрийн тэгш байдлыг хангахын тулд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт хийхэд анхаарлаа хандуулах болсон.

Төсвийн үе шатуудад жендэрийг тусгах

Жендэрийн тэгш байдлыг дэмжихэд төсвийн бодлого, удирдамжийг төсвийн үе шат бүрт тусгаж болно. Үүнд:

- Бэлтгэх, төлөвлөх
- Батлах
- Хэрэгжүүлэх
- Үнэлэх

Төрийн албан хаагчдын хувьд жендэрийг тусгахдаа

Дээрх дөрвөн үе шатны гуравт нь төрийн албан хаагч шууд гар бие оролцож, нөлөөлөх боломжтой. Үүнд:

- Бэлтгэх, боловсруулах
- Хэрэгжүүлэх
- Үнэлэх

Төрийн үйлчилгээг ард иргэдэд тэгш хүртээх байдлыг сайжруулах үүднээс үе шат болгонд хүйсийн тусгайлсан шинжилгээг хийж болох юм.

Merci.
